



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсэг, 10<sup>1</sup> дугаар зүйлийн 10<sup>1.2</sup> дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 18 дугаар тогтоол, 2015 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 336 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих зорилгоор зам, тээврийн салбарт худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, тогтоомжийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллахыг яамны газар болон харьяа байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

1.1. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт"-д заасан барааг нийлүүлэх шалгуур шаардлагыг тендерийн баримт бичигт тодорхой зааж, дотоодын үйлдвэрлэгчийн бараа бүтээгдэхүүнийг худалдаж авах чиглэлийг баримтлах;


1.2. Зам, тээврийн салбарт бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дотоодын үйлдвэрлэгчийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн сонгохыг дэмжих, дотоодын давуу эрх тооцох нөхцөлийг тендерийн баримт бичигт тусгаж ажиллах;

1.3. Дотоодын аж ахуй нэгжүүдийн ирүүлсэн тендерийн үнийг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасны дагуу хийсвэрээр бууруулж тооцох;

1.4. Тендерт оролцогчдод давуу эрх олгохдоо Сангийн сайдын 2007 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 81 дүгээр тушаалаар батлагдсан "Тендерт оролцогчдод давуу эрх олгох аргачлал"-ыг мөрдлөг болгон ажиллах.

2. Тендерт оролцогчдод давуу эрх олгосон талаарх мэдээг худалдан авах ажиллагааны улирлын тайланд дэлгэрэнгүй тусган тайлагнахыг харьяа байгууллагуудын дарга нарт даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.



САЙД

Ж.БАТ-ЭРДЭНЭ

080056